



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 666

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгийг балансаас балансад ┐ шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 4 нэрийн, нийт 20,900,000.00 (хорин сая есөн зуун мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгө (автомашин)-ийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 17,000,000.00 (арван долоон сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Нямгэрэл, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, цагдаагийн хурандаа Т.Сүхболд болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006821
34-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн
66 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА АВТОБААЗЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашины нэр, марк, улсын дугаар, арлын дугаар	Ашиглалтад орсон, дахин үнэлсэн он	Тоо шир хэг	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)			Хүлээн авах байгууллагын нэр
					Цаашид ашиглах хугацаа (жилээр)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)	
1	Тоёота ландркрузер-78, дизель, 17-54 УБЗ (арал-JTERB71J300042658)	2008/2022	1	6,100,000.00	3	6,000,000.00	6,000,000.00	"Булган-АЗЗА" ТӨХК
2	Ниссан пикап, дизель, 37-41 УНБ (арал-JN1CJUD22Z0095120)	2008/2021	1	5,000,000.00	3	4,000,000.00	4,000,000.00	
3	Хьюндай соната-7, 51-49 УАТ (арал-KLMHET41AP9A.701803)	2007/2021	1	4,300,000.00	3	3,000,000.00	3,000,000.00	Говь-Алтай аймаг дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв ХХЕГ-ын харьяа
4	Хьюндай соната-7, 01-90 УНУ (арал-KMHEB41BACA396099)	2012/2021	1	5,500,000.00	3	4,000,000.00	4,000,000.00	Зорчигчийн мэдээллийн төв
Нийт дүн							17,000,000.00	